



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах товчоо
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Орон сууц хувьчлах товчооны ажиллах журмын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2. Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, "Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам"-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.

3. Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Орхон аймгийн Засаг дарга Д.Батлутад зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны Орон сууц хувьчлах товчоо байгуулах тухай" 199 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000042

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 13 дугаар сарын 3/-ны
өдрийн 98 тогтоолын хавсралт



ОРХОН АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга:

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хууль, эрх зүйн хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Орон нутгийн өмчийн газрын дарга

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын
Нийгмийн харилцааны хэлтсийн
орлогч дарга